

7 хоногийн мэдээ

1. Ногооннуур сумын Чихтэй баг, Улаанхус сумын ᠗ х хөтөл багуудад сүрьеэгийн идэвхтэй идэвхтэй илрүүлэг зохион байгуулж 114 хүн сүрьеэгийн шинжилгээнд хамрагдсанаас эерэг тохиолдол илрээгүй.
2. Ховд их сургуулийн Баян-Өлгий дэхь салбар сургуулийн 30 оюутан, Монгол Туркийн хамтарсан сургуулийн дунд болон ахлах ангийн 200 гаруй сурагчдад, аймгийн 200 гаруй иргэд, таксины жолооч 1᠐нд АНЭ-ийн нийгмийн ажилтан, сургуулийн эмчтэй хамтарч ХДХВ/ДОХ-ын талаар сургалт явуулсан.
3. Цэнгэл сумын нутаг дэвсгэрт байрлах SS Mongolia компанийн 60 уурхайч, тогооч, оффисийн ажилчдыг хамруулан БЗДХ/ХДХВ/ДОХ, сүрьеэ өвчний талаар сургалт явуулсан. Глобаль сангаас хувиарлагдсан бэлгэвчнээс 2 хайрцаг, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх гарын авлагыг тараасан. уурхайч 60 үжийг ХДХВ/ДОХ, тэмбүүгийн хурдавчилсан шинжилгээнд хамруулсан. Эерэг тохиолдол илрээгүй болно.
4. Томуугийн улирал эхэлсэнтэй холбоотой ӨСҮТ -өөс нийт 1220 хүн тун томуугийн эсрэг вакцин ирж, үүнээс эмч эмнэлгийн ажиллагсад 782 хүн, эрсдэлт бүлгийн 383 хүн, сайн дурын дархлаажуулалтад 31 хүн хамрагдаж, хамралт 98 хувьтай байна.

Зарим статистик үзүүлэлтүүд

Нийт төрөлт - 35

Амьд төрөлт - 35

Амьгүй төрөлт- 0

Дутуу төрөлт - 3

Нялхсын эндэгдэл- 1

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл-0

Эхийн ноцтой хүндрэл- 0

Төрөлхийн гажиг- 0

Гэрийн төрөлт- 0

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 48 дугаар долоо хоногт нийт 3172 хүн үйлчлүүлсний 150 (4,7%) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 1,4%-иар өссөн үзүүлэлтэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (168)-ийн дотор 26 буюу 15.4 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 5,7 %-иар өссөн үзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 288 дуудлагын 45 (15,6%)-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 7,6%-иар өссөн үзүүлэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 48 дугаар 7 хоногт аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын тандалтын нэгжүүд Томуу, томуу төст өвчний тохиолдол 18 удаа ирүүлэхээс 17(94,4%) удаа ирүүлсэн байна.

ЭМНЭЛЭГ, СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮД ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ТОМУУГИЙН ХАРУУЛДАН ТАНДАЛТЫН 48 ДАХ 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

Д/Д	Эрүүл мэндийн байгууллага	Нийт үзлэг	Томуу,томуу төст өвчний тохиолдол	Эзлэх хувь	Өмнөх долоо хоногтой харьцуулбал	Түргэн тусламжийн дуудлага	Томуу төст өвчний дуудлага	Түргэн тусламжийн Эзлэх хувь	Өмнөх долоо хоногтой харьцуулбал
1	Алтай	147	7	4.7%	2,5%	12	7	58.3%	0%
2	Алтанцөгц	25	5	20%	20%	1	0	0%	0%
3	Булган	104	0	0%	0%	33	0	0%	0%
4	Баяннуур	151	26	17.2%	5,7%	4	0	0%	0%
5	Бугат	23	0	0%	3,8%	6	0	0%	0%
6	Буянт	47	5	10.6%	6%	6	2	33.3%	0%

7	Дэлүүн	98	10	10.2%	9,2%	8	4	50%	0%
8	Ногооннуур	83	0	0%	0%	9	0	0%	0%
9	Сагсай	13	6	46.1%	0%	5	4	80%	0%
10	Толбо	0	0	0%	20%	0	0	0%	0%
11	Улаанхус	119	23	19.3%	10,4%	24	7	29.1%	31,8%
12	Цагааннуур	82	7	8.5%	7,3%	15	0	0%	0%
13	Цэнгэл	287	11	3.8%	6%	19	0	0%	0%
14	Жансая	141	12	8.5%	3,1%	0	0	0%	0%
15	Мейрим	416	0	0%	1,5%	0	0	0%	0%
16	Рауан	242	0	0%	0%	7	0	0%	0%
17	Шипагер	410	1	0.2%	0,5%	0	0	0%	0%
18	Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үзлэг	784	37	4.7%	4,6%	139	21	15.1%	11,9%
	Эмнэлэгт хэвтэгсэд	168	26	15.4%	9,7%				
Нийт	Аймгийн хэмжээнд	3172	150	4,7%	3,3%	288	45	15,6%	8,%

Аймгийн хэмжээнд 47 дах долоо хоногт тандалтын нэгжүүдээс мэдээ ирүүлэлтийн байдалаар 84,6%-тай байсан бол 2018 оны 48 дах долоо хоногт мэдээ ирүүлэлт 88,8% -тай байна. Нэг сум мэдээ тасалсан байна.